



“ТЭН ХУН” ХХК

НАРАНТОЛГОЙН АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСӨЛ

**ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН НУТАГТ ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ТЭН ХУН ХХК-ИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Улаанбаатар
2025**

БАТЛАВ.

БОУАӨЯ-ны ХБОБЗГ-ын дарга/Г. Энхмөнх/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН.

“Тэн Хун” ХХК-ийн ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ. /Сун Хуй/



ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ТЭН ХУН ХХК-ИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР-713А/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР-2839717/

Хянасан:

БОУАӨЯ-ны ХБОБЗГ-ын газрын ахлах шинжээч...../Ц. Жаргалнэмэх/

Боловсруулсан:

“Тэн Хун” ХХК-ийн БОХАБЭАХ-ийн дарга..... /Б. Пүрэвбат/

“Тэн Хун” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн /Н. Одончимэг/

АГУУЛГА

1. НАРАНТОЛГОЙН УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	7
1.1. Түүхэн товчоо.....	10
1.2. Нарантолгойн алтны ордны геологийн бүтэц	11
1.3. Цаг уур, уур амьсгалын онцлог	12
1.4. Нарантолгойн уурхайн техник эдийн засгийн үндэслэл.....	13
1.5. Уурхайн гол барилга байгууламж.....	14
1.5.1. Далд уурхайн барилга байгууламж	15
1.5.2. Баяжуулах үйлдвэр	16
1.5.3. Хаягдлын далан.....	18
1.5.4. Цахилгаан эрчим хүчний хангамж	20
1.5.5. Усан хангамж	22
1.5.6. Химийн бодисын агуулах	23
1.5.7. Баяжуулах үйлдвэрийн лаборатори.....	24
1.5.8. Техникийн засвар үйлчилгээний барилга байгууламж.....	25
1.5.9. Тэсрэх материалын агуулах.....	26
1.5.10. Түлшний агуулах ба шатахуун түгээх станц (ШТС)	27
1.6. “Тэн Хун” ХХК-ний байгаль орчны үнэлгээ, холбогдох зөвшөөрлүүд	28
1.6.1. “Тэн Хун” ХХК-ны эзэмшдэг тусгай зөвшөөрөл.....	28
1.6.2. Газар ашиглах зөвшөөрөл, гэрчилгээ.....	28
1.6.3. Байгаль орчны холбогдох зөвшөөрөл	28
1.6.4. Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тайлан.....	29
1.7. Уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, нийт зардал	29
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	29
2.1. Уур амьсгал	30
2.2. Хөрс, ургамал зүй.....	31
2.3. Ус зүй.....	31
2.4. Ан амьтан.....	31
2.5. Ордын геологийн тогтоц.....	31
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	33
3.1. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	33
3.2. Хөрсөнд учирч болзошгүй нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээ.....	34

3.3. Ургамал, амьтанд учирч болзошгүй нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээ.....	34
3.4. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл	35
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	35
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	36
5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	36
5.2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	37
5.3. Усны нөөц, чанарын асуудал	39
5.4. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	41
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	42
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	43
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	43
9. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	44
10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	45
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	49
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	51
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	51
14. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	52
14.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ	53
14.2. Хөрсний хяналт шинжилгээ.....	54
14.3. Усны чанарын хяналт шинжилгээ	55
14.4. Ургамлын аймаг, нөхөн сэргээлтийн дараах хяналт шинжилгээний хөтөлбөр	56
15. ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТУУД.....	58

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. “Тэн Хун” ХХК-ийн мэдээлэл.....	9
Хүснэгт 2. Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицолууд	9
Хүснэгт 3. “Тэн Хун” ХХК-ийн эзэмшдэг ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд	28
Хүснэгт 4. Газар ашиглалтын зөвшөөрөл, гэрчилгээ.....	28
Хүснэгт 5. Байгаль орчны холбогдох зөвшөөрөл, хүчинтэй хугацаа.....	28
Хүснэгт 6. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	36
Хүснэгт 7. Хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	38
Хүснэгт 8. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	39
Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	45
Хүснэгт 10. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	49
Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	51
Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалт төлөвлөгөө.....	52
Хүснэгт 13. Агаарын чанарын хяналт шинжилгээ.....	53
Хүснэгт 14. Хөрсний хяналт шинжилгээ	54
Хүснэгт 15. Усны чанарын хяналт шинжилгээ	55
Хүснэгт 16. Ургамлын аймаг, нөхөн сэргээлтийн дараах хяналт шинжилгээний хөтөлбөр	56

ЗУРАГ


Зураг 1. Нарантолгой уурхай.....	7
Зураг 2. Нарантолгойн уурхайн байршил	8
Зураг 3. Хүдрийн биетийн хэлбэр, хэмжээ (блок загварчлалаар, хойшоо харсан байдал).....	11
Зураг 4. Цаг уурын ОЖД мэдээ, Жаргалант сумын цаг уурын харуулын мэдээ	12
Зураг 5. Нарантолгойн алтын уурхайн захиргаа, ажилчдын байрны цогцолборын бүдүүвч зураг.....	14
Зураг 6. Далд уурхайн босоо ам.....	15
Зураг 7. Баяжуулах үйлдвэр.....	16
Зураг 8. Хаягдлын далан	18
Зураг 9. Хаягдлын далангийн схем.....	19
Зураг 10. Уурхайн дэд станц оролтын шугамын хүчин чадал (35000V).....	20
Зураг 11. Уурхайн гадаад цахилгаан хангамжийн ерөнхий байршил.....	21
Зураг 12. Уурхайн дотоод цахилгаан хангамжийн ерөнхий схем.....	21
Зураг 13. Ахуйн болон технологийн хэрэглээний гүний худаг.....	22
Зураг 14. Химийн бодисын агуулах	23
Зураг 15. Баяжуулах үйлдвэрийн лаборатори.....	24
Зураг 16. Техникийн засвар, үйлчилгээний барилга.....	25
Зураг 17. Тэсрэх материалын агуулах	26
Зураг 18. Шатахуун түгээх станц	27
Зураг 19. Цаг уурын ОЖД мэдээ, Жаргалант сумын цаг уурын харуулын мэдээ	30
Зураг 20. Монгол орны хөрсний зураг	31
Зураг 21. Ордын геологийн зураг	32
Зураг 22. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	41
Зураг 23. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	43
Зураг 24. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	44

1. НАРАНТОЛГОЙН УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нарантолгой алтны үндсэн ордыг 1966-1970 онуудад Герман геологичид илрүүлж байсан бөгөөд 2013 онд нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэж 2015 онд улсын нэгдсэн нөөцийн санд бүртгүүлсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын нутагт орших 375.18 га талбай бүхий ашигт малтмал ашиглах MV-000713 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд Нарантолгойн алтны үндсэн ордыг эзэмшиж байгаа бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь 2037 он хүртэл хүчинтэй, АМТХуулийн дагуу 10 жилээр 2 удаа сунгагдах эрх нь нээлттэй. БНХАУ-аас 100 хувийн хөрөнгө оруулалттай компани бөгөөд 2006 оноос эхлэн хөрөнгө оруулалт хийгдсэн.

БНХАУ-ын Янтай Тэн Хун компани нь 2004 оны 7 дугаар сард Монгол Улсад хөрөнгө оруулан Тэн Хун ХХК-ийг анх байгуулсан. Манай компани нийт 185 ажилчидтай үүнээс 25 ажилчин нь хятад 160-н монгол ажилчидтай болно. 2006 оноос эхлэн уг ордыг ашиглалтанд бэлтгэх зорилгоор далд уурхайн малталт нэвтрэлтүүдийг хийх, хуучин малталтуудыг сэргээн засварлах, барилга байгууламжуудыг барих, дэд бүтцийг хөгжүүлэх, ордыг ашиглах эрхзүйн баримт бичгийг боловсруулж батлуулах зэрэг бэлтгэл ажлуудыг хийж улмаар 2010 оноос далд уурхайн ашиглалтыг эхлүүлсэн. Нийт ажилчид нь Үйлдвэр төлөвлөтийн хэлтэс, Дотоод хяналтын хэлтэс, Байгаль орчин хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэлтэс, Баяжуулах үйлдвэр, Санхүүгийн хэлтэс, Хангамжийн хэлтэс, Хүний нөөц захиргаа удирдалгын хэлтэс, Тоног төхөөрөмж засвар үйлчилгээний хэлтэс гэсэн 8-н хэлтэст хувиарлагдан ажилладаг.



Зураг 1. Нарантолгой уурхай


Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

Уурхай байршил: “Тэн Хун” ХХК-ийн олборлолт явуулж буй “Нарантолгойн алтны үндсэн орд” нь Төв аймгийн Жаргалант суманд байрладаг аймгийн төвөөс 140 км, Улаанбаатар хотоос баруун хойш 130 км зайд байрладаг.

Төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд мал аж ахуй, газар тариалан голлон эрхэлдэг. Сүүлийн жилүүдэд алт, нүүрс олборлолтын үйл ажиллагаа эрхлэх болсон бөгөөд газар тариалан хүнсний ногоо, фермерын аж ахуй хурдацтайгаар хөгжиж байгаа дэд бүтэц сайн хөгжсөн төвийн нутагт байрлаж байгаа болно.

Сүхбаатар-Улаанбаатар хотыг холбосон хатуу хучилттай засмал зам ордоос зүүн тийш 12 км-н зайтай өнгөрнө. 2013 онд энэ замаас Жаргалант сум хүртэл хатуу хучилттай засмал зам тавигдсан бөгөөд энэ замаас төслийн талбай хүртэл 7 км сайжруулсан шороон замтай. Нарантолгойн ордоос зүүн хойд зүгт 52 км-т Дархан-Улаанбаатарын төмөр зам өнгөрдөг.

Нарантолгойн ордоос урагш 2-3 км зайд Борнуур, Цагаан булагийн 110 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, Борнуур, Угтаалыг холбосон 35 кВ-ын цахилгаан шугам зэрэгцэн өнгөрнө. Нарантолгойн уурхай нь Борнуур-Жаргалантын 35 кВ-ын цахилгаан дамжуулах шугамаас гэжээгдэж байна.



Зураг 2. Нарантолгойн уурхайн байршил

Ангилал: Нарантолгойн алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төсөл /Далд аргаар ашиглах уурхайн ТЭЗҮ-ийг боловсруусан/

Төслийн зорилго, ач холбогдол: Нарантолгойн алтны үндсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар, улс орон нутгийн экспортын орлого нэмэгдэхээс гадна уурхай болон уурхайг дагалдан тухайн бүс нутагт ханган нийлүүлэгч, үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэл хөгжих, аж ахуй нэгжүүд шинээр байгуулагдаж, олон тооны ажлын байр бий болж, орон нутагт ажил эрхлэлт нэмэгдэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, шинээр хүн амын төвлөрөл бий болох зэрэг олон эерэг нөхцөл бүрдэх болно.

Хүснэгт 1. “Тэн Хун” ХХК-ийн мэдээлэл

Нарантолгой төслийг хэрэгжүүлэгч аж ахуй нэгж	Аж ахуй нэгжийн Улсын бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Нарантолгой ХХК-ийн хаяг, байршил
“Тэн Хун” ХХК	9019016020	Төв аймгийн Жаргалант сумын нутагт байрлах “Нарантолгойн алтны үндсэн орд”-ын төсөл	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Богд-Ар хороолол, 2а байр 14 тоот

Ажиллах хүчний тухай: Нарантолгойн алтны уурхай нь жилд 81000 тн хүдэр олборлох хүчин чадалтай бөгөөд төслийн ТЭЗҮ-д баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг тооцохдоо далд уурхайн хүчин чадал, захиалагчийн хүсэлт, уурхайн хэтийн төлөв, бүс нутгийн цаг уурын нөхцөл зэргийг харгалзан үзэж 12 тн/цаг хүчин чадалтай байхаар тооцсон байна. Нарантолгойн уурхай нь жилийн турш тогтмол үйл ажиллагаатай байх бөгөөд олборлолт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа бүрэн хүчин чадлаараа ажиллаж жигдэрсэн тохиолдолд 206 орчим үндсэн ажилтан /уурхайн удирдлага, ИТА-10%, тусгай мэргэжлийн ажилтан-70%, бусад-20%, 80 орчим түр хугацааны гэрээт ажилтан байхаар төлөвлөж байна.

Хүснэгт 2. Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицолууд

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	105	55	51.11	48	33	53.88
2	105	55	51.11	48	34	29.87
3	105	56	16.12	48	34	29.87
4	105	56	16.12	48	35	10.88
5	105	55	6.12	48	35	10.88
6	105	55	6.12	48	34	29.87
7	105	54	26.12	48	34	29.87
8	105	54	26.12	48	33	53.88
9	105	55	51.11	48	33	53.88

1.1. Түүхэн товчоо

Уурхай эхэлсэн огноо: Нарантолгойн алтны үндсэн орд нь Төв аймгийн Жаргалант сумын нутагт Улаанбаатар-Дархан-Сэлэнгийн засмал замын баруун хэсэгт 20 км орчим зайд оршино. Уг орд нь кварц-бага сульфид-алтны орд бөгөөд үндсэн 1 судал, түүнтэй зэрэгцээ 2 жижиг судлын хэсэг 3 биетээс тогтоно.

Нарантолгойн орд нь босоо-налуу уналттай урт сунасан судлын төрлийн орд бөгөөд далд аргаар ашиглалт явагдаж байгаа орд юм.

1966-1968 онд явуулсан нарийвчилсан эрлийн ажлаар Хэнкель нарын геологиуд (1968) Нарантолгойн орчимд тархсан кварцын судлуудыг гадаргуугаас нь дээжлэн кварцын судлын төрлүүдийг тогтоон, алттай кварцын судлуудыг ялгасан. 1968-1970 онд явуулсан хайгуулын ажлын дүнд Хэнель нар (1971) Нарантолгойн алттай кварцын судлуудыг гадаргуугаас нь сувгаар нээж ховилон сорьцлолт хийсэн ба Үндсэн, Зэрэгцээ судлуудад өрмийн цооног болон далд малталтуудаар хайгуул хийж алт, мөнгөний нөөцийг тооцоолсон.

Нарантолгойн ордын ТЭЗҮ-ийг анх 2009 онд “Уул уурхайн хүрээлэн” гүйцэтгэж байсан бөгөөд ТЭЗҮ-ийн тодотголыг 2015 онд “Абсолютмайнинг” ХХК гүйцэтгэсэн байна.

Уг ТЭЗҮ-ийн тодотгол-1-ийг боловсруулахдаа ордыг 9 жилийн хугацаанд далд уурхайн аргаар, шпурын цэнэгээр тэсэлж, хоршоолон нураан олборлох системээр үргэлжлүүлэн ашиглана.

Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг боловсруулах ажлыг Геологи, Уул уурхайн зөвлөх үйлчилгээ, зураг төслийн “Гоулдмэн Прожект” ХХК-ийн инженерүүд, МУ-ын зөвлөх инженер С. Ичинноров зөвлөснөөр холбогдох хууль дүрэм, журмын хүрэн хийж гүйцэтгэсэн.

1982 онд Бороогийн алтны ордын хайгуулын ажлыг хийсэн Монгол-Германы геологичид Нарантолгойн ордын нөөцийг дахин тооцоолсон. 1997 онд Нарантолгойн ордод ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон ч ашиглалтанд бэлтгэж амжилгүй байтал “Нинжа” нар Германиудын малтсан хэвтээ амыг дур мэдэн орж штольнийн түвшин, түүнээс дээш болон доош орших блокуудад олборлолт хийсэн байгаа юм. 2004 оны 7 дугаар сард БНХАУ-ын Янтай Тэн Хун компани Монгол Улсад хөрөнгө оруулан “Тэн Хун” ХХК-ийг анх байгуулсан.


Алтны хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар “Тэн Хун” ХХК нь “Восток-Эрдэс” ХХК-ийн MV-000713 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг ГУУКА-ын даргын 2005 оны 04 дугаар сарын 02-ны өдрийн 173 тоот шийдвэрээр 375.18 га “Нарантолгой” нэртэй талбайг шилжүүлэн авсан.

Манай компани нь Төв аймгийн Жаргалант сумын нутагт орших 375.18 га талбай бүхий ашигт малтмал ашиглах MV-000713 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд Нарантолгойн алтны үндсэн ордыг эзэмшиж байгаа бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь 2037 он хүртэл хүчинтэй, АТТХуулийн дагуу 10 жилээр 2 удаа сунгагдах эрх нь нээлттэй. БНХАУ-аас 100 хувийн хөрөнгө оруулалттай компани бөгөөд 2006 оноос эхлэн хөрөнгө оруулалт хийгдсэн.

1.2. Нарантолгойн алтны ордны геологийн бүтэц

Нарантолгойн орд нь террейний ангиллаар (Г. Бадарч ба бусад, 2002) арлан нумын бассейн болох Хараа террейнд (Хараа голын бүс) байрлах ба Хараа террейнтэй металлогений дүүрэгчлэлээр давхцдаг Хойд Хэнтийн алтны металлогений бүсийн Бороо-Зуун модны хүдрийн дүүрэгт оршино. Хойд Хэнтийн бүс нь өмнөд, зүүн өмнөд талаараа Ерөө голын хагарлын бүс (Сүжигтэйн), баруун хойд, баруун талаар Баян голын гүний хагарлаар тус тус хязгаарлагддаг.

Хараа группын хурдас дотор дээд пермийн гранодиоримийн хил заагийн хэсэг илэрсэн гидротермаль хувирлын бүс бүхий нэлээд их талбайд болон гүн рүү үргэлжилсэн хэсэгт Кварцийн үндсэн ба зэрэгцээ судлууд байрлана. Мөн кварцийн судлын салбарласан хэсэг, олон тооны янз бүрийн чиглэлд (зүүн, хойш, зүүн хойш) сунасан кварцийн хялгасан судлууд тохиолдоно.




Зураг 3. Хүдрийн биетийн хэлбэр, хэмжээ (блок загварчлалаар, хойшоо харсан байдал)

Нарантолгойн алтны ордын хүдрийн хэмжээ, металлын шинэчилсэн нөөцийн тооцоог “Авсолют Майнинг” ХХК Майкромайн программын блок загварчилалд утга тараах арга ашиглан Бодитой (В) зэргээр ордын хэмжээнд 6.37 г/т алтны дундаж агуулгатай 388,489.00 тн хүдэр бүхий 2744.13 кг алт, Боломжтой (С) зэргээр 7.44 г/т алтны дундаж агуулгатай 695,000.50 тн хүдэр бүхий 5813.13 кг алтыг тус тус тооцоолж, нийт (В+С) 6.88 г/т алтны дундаж агуулга бүхий 1,083,489.51 тн хүдэр буюу 8557.26 кг алтны нөөцийг тооцсон байна. АМГ-ын 2015-03-24 өдрийн Н/26 тоот тушаал болон 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн УУЯ, АМГ-н ХХ-01-12 дугаар бүхий Эрдэс баялагийн зөвлөлийн дүгнэлтээр 736,479.48 хүдэр буюу 8185,35 кг алт, 36178,49 кг мөнгө гэж баталсан байна.

1.3. Цаг уур, уур амьсгалын онцлог

Эх газрын эрс тэс уур амьсгалтай, агаарын температурын хоногийн хэлбэлзэл нэлээд өндөр (хавар, намар). Өвлийн улирал нь хахир, хүйтэн, 11-р сараас 3-р сар хүртэл харьцангуй удаан үргэлжилнэ. Хамгийн их хүйтэн нь 1-р сард -48°C -д хүрнэ. Тогтвортой цасан бүрхүүл 11-р сарын дундаас 3-р сарыг дуустал үргэлжилдэг. Хөрсний хөлдөлт 9-р сарын дундаас 5-р сарын сүүлч хүртэл үргэлжлэх бөгөөд гүн нь өвөлдөө 3.0 м хүрэх боловч мөнх цэвдэг байдаггүй. Хаврын улирал 3-р сарын сүүлчээс 6-р сарын эхэн хүртэл үргэлжлэх ба хоногийн температурын хэлбэлзэл ихтэй, агаарын хуурайшилт их, хүчтэй салхитай байдаг. Зун нь бусад улирлаас арай богино, агаарын хамгийн их халуун 7-р сард нэмэх $19-26^{\circ}$ -д хүрнэ. Жилд орох хур тунадасны хэмжээ 300-400 мм, түүний 60-80% нь 7, 8-р саруудад унадаг бөгөөд хур тунадастай өдрийн тоо жилд дунджаар 60 хоног. Салхины дундаж хурд 4-8 м/сек, голдуу баруун-хойд, хойд, зүүн-хойд зүгээс салхилах бөгөөд заримдаа 20-22 м/сек хүрдэг (Монгол Улсын Үндэсний атлас, 2009 он).

Жаргалант суманд 1964 оноос цаг уурын харуул ажиллаж байсан ба 1993 онд цаг уурын өртөө байгуулагдсан. Уг цаг уурын өртөө хойд өргөргийн $48^{\circ}31'$, зүүн уртрагийн $105^{\circ}53'$ -т, далайн түвшнээс дээш 990 м өндөрт оршино.



Зураг 4. Цаг уурын ОЖД мэдээ, Жаргалант сумын цаг уурын харуулын мэдээ

Судалгааны талбай нь газар зүйн байрлалаар Хэнтий уулсын баруун хэсгийн захын нам уулсын бүсэд байршина. Орд нь Монгол орны хангай, тал хээрийн завсрын бүсэд хамаарах бөгөөд газрын гадаргуугийн өндөржилт нь Нарантолгой уул 1246.2 м, Жаргалантын гол, Тал булагийн гол, Бяцхан булагийн хөндийнүүдээр эргэн тойроны уул толгодоос тусгаарлагдсан харьцангуй өндөр уулсыг бүрдүүлж байна. Нарантолгой уул нь хойноосоо урагш сунаж тогтдог бөгөөд уулын хойд хэсэг нь бүнхэр хэлбэрийг үүсгэнэ. Энэ уул нь 1-2 м-ийн гүнтэй олон тооны хуурай жалга сайруудаар хэрчигдсэн байна.

Усан сүлжээ нь Хойд мөсөн далайн ай савд багтах ба талбайн баруун хэсгээр Жаргалантын тогтмол урсацтай гол урсаж Загдалын голд цутгадаг. Загдалын гол нь Хараагийн голд цутгана.

1.4. Нарантолгойн уурхайн техник эдийн засгийн үндэслэл

Төсөл хэрэгжүүлэгч “Тэн Хун” ХХК нь Төв аймгийн Жаргалант сумын нутагт орших Нарантолгойн алтны үндсэн ордыг Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайн ашиглалтыг явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, далд уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

Нарантолгойн алтны үндсэн ордыг 1966-1970 онуудад Германы геологичид илрүүлж байсан бөгөөд 2013 онд нарийвчилсан хайгуулын ажлын гүйцэтгэж 2015 онд улсын нэгдсэн нөөцийн санд бүртгүүлсэн байна.

Алтны хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар “Тэн Хун” ХХК нь “Восток-Эрдэс” ХХК-ийн MV-000713 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг ГУУКА-ын даргын 2005 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 173 тоот шийдвэрээр 375.18 га “Нарантолгой” нэртэй талбайг шилжүүлэн авсан.

Нарантолгойн алтны үндсэн ордод хамаарах MV-000713 дугаартай тусгай зөвшөөрлийг БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Тэн Хун” ХХК эзэмшиж байгаа бөгөөд уг ордыг далд уурхайгаас ашиглах ТЭЗҮ-ийг 2009 онд Уул уурхайн хүрээлэн боловсруулж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулсан. Энэхүү ТЭЗҮ-ийг боловсруулах явцад Уул уурхайн хүрээлэнгийн мэргэжилтнүүд мэргэжлийн шинжээчдийн баг бүрдүүлэн ажиллаж зохих дүгнэлтүүдийг хийсэн.

Төв аймгийн Жаргалант суманд орших MV-000713 тоот тусгай зөвшөөрөлд Нарантолгой алтны үндсэн ордод 2013 онд хийгдсэн нөөцийг дахин тооцож шинэчилсэн нөөцийн тооцоог 2014 он “АВСОЛЮТ МАЙНИНГ” ХХК нөөцийг дахин тооцож шинэчилсэн нөөцийг Эрдэс баялгийн зөвлөлд оруулжээ. Ашигт малтмалын газрын 2015-03-24 өдрийн Н/26 тоот тушаал болон 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн УУЯ, АМГ-н ХХ-01-12 дугаар бүхий Эрдэс баялагийн зөвлөлийн дүгнэлтээр нөөцийг баталж хүлээн авсан.


Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Ашигт малтмал, газрын тосны газар эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2021.05.19-ны өдөр “Тэн Хун” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Тоулдмэн Прожект” ХХК боловсруулсан Төв аймгийн Жаргалант сумын нутагт орших Нарантолгойн алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг хэлэлцэж № Т/21-09-07 дүгнэлтийг гаргасан. Энэхүү дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Т/211 тоот тушаалаар Нарантолгой алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол /1/-ыг хүлээн авсан. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэл нь ерөний мэдээлэл, геологи, далд уурхайн технологи, баяжуулах үйлдвэр, дэд бүтэц, эдийн засаг, байгаль орчин, хөдөлмөр хамгаалал гэсэн хэсгүүдээс бүрдэх ба төслийн мэдээллийг ерөнхий байдлаар үзүүлсэн байна.

1.5. Уурхайн гол барилга байгууламж

Нарантолгойн алтны үндсэн ордыг ашиглах далд уурхайн гадаргуугийн барилга байгууламжуудад уурхайн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах бүх барилга байгууламжуудыг бий болгосон.

Нарантолгойн уурхайд 2006-2017 оны хооронд хөрөнгө оруулалт жил бүр хийгдэж ирсэн бөгөөд нийт 11.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Тус хөрөнгө оруулалтын үлдэгдэл өртөг нь 2020 оны 01-р сарын 01-ний байдлаар 2.86 тэрбум төгрөг байна.

Уурхайд ажиллах ажилчид нь уурхай дээр байрлах бөгөөд 52x8 м талбай бүхий 6-12 өрөөтэй, сэндвич хавтангаар барьсан 12 ширхэг нэг давхар байрнууд (Зураг 3), спорт заал, автограж, уурын зуух, хоолны газар, угаалгын байр, эмнэлгийн байр, хүнсний агуулах, зочид буудал, шатахуун түгээх газар зэрэг цогцолборыг баяжуулах үйлдвэрийн урд талд тусгай талбайд барьж байгуулсан болно. Мөн 3-н давхар тоосгоор барьсан уурхайн оффисын байрыг 2012 онд барьж ашиглалтанд оруулсан байна. Уурхайн оффисын байр ашиглалтанд орсноор ажилчдад хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг тогтмол явуулах болсон байна.



Тайлбар: 1- Усны өрөө, 2- Уурын зуух, 3- Агуулах, граж, 4- Ажилчдын өрөө, 5- Эмэгтэй ажилчдын өрөө, 6- Соёлын танхим, 7- Хоолны газар, 8- Гал тогоо, 9- Хогийн цэг, 10- Гадаа жорлон, 11- Ус буцалгах өрөө, 12- Нүүрсний агууламж, 13- Спортын талбай, 14- Хурлын танхим, 15- Уурхайн хэлтэс, тасаг, 16- Уурхайн захиргаа, эмнэлгийн пункт

Зураг 5. Нарантолгойн алтын уурхайн захиргаа, ажилчдын байрны цогцолборын бүдүүвч зураг

1.5.1. Далд уурхайн барилга байгууламж

Нарантолгойн алтны үндсэн ордыг ашиглах далд уурхайн үндсэн барилга байгууламжинд хүдрийн биетийг нээхэд зориулагдсан 3 гол ам №1, №2, №3, №4, босоо мухар ам №2 нэмж гүнзгийрэх ба түвшний агааржуулалтын болон тээврийн штрекүүд, кваршлегүүд, уурхайн их амуудын ойролцоох байгууламж зэрэг малталтуудыг шинээр нэвтрэхээр байна.

Далд уурхайн ашиглалтын явцад уулын малталтаар хайгуул хийж, нөөцийг нэмэгдүүлэх, өсгөх боломжийг судлах бөгөөд суналын дагуу хоёр тийшээ болон гүнрүү нөөц өсөх магадлалтай байгаа болно.



Зураг 6. Далд уурхайн босоо ам

1.5.2. Баяжуулах үйлдвэр

Баяжуулах үйлдвэрийн барилга нь 100 х 40 м талбай бүхий хүдэр бутлах, баяжуулах, хаягдлыг саармагжуулах хэсэг цехүүд зэргээс бүрдэнэ. Нарантолгойн алтны үндсэн ордын хүдрийг БНАГУ-ын Фрайбергийн эрдэм шинжилгээний институт болон ЗХУ-ын “ВНИЙ промзолото” институтэд лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтын үр дүнд тулгуурлан БНХАУ-д түгээмэл хэрэглэгдэж байгаа гравитац болон цианаар уусгах (CIP технологи) баяжуулалтын аргыг хэрэглэж боловсруулалт хийхдээ 2 шатны бутлуур сонгож авсан.



Зураг 7. Баяжуулах үйлдвэр


Баяжуулах технологи нь алтыг цианаар уусгаж, электролизийн аргаар тунгаан цэвэршүүлээд, металлургийн аргаар хайлуулан боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Баяжуулах үйлдвэр өдөрт 300 тн, жилд 9×10^4 тн хүдэр боловсруулж, баяжуулах металл авалт 90.5%, хайлуулах металл авалт 99% байх бөгөөд жилийн 300 хоногт үйлдвэрлэл явуулж, жилд 260 кг алт, 200 кг мөнгө гаргаж авахаар тооцоолсон.

Баяжуулах үйлдвэр нь дараах үндсэн цех хэсгүүдтэй. Үүнд:

- Бутлах цех
- Баяжуулах цех
- Хаягдлын сан

Бутлах цех нь 27 x 6.6 м талбай эзэлсэн нэг давхар барилга бөгөөд дотроо 350 мм-ийн хөдөлгөөнгүй шигшүүр бүхий 900 x 1240 маркийн бутлуурын тэжээгч, засварын ажилд хэрэглэх өргөх төхөөрөмж, 2 шатны хацарт бутлуур, туузан дамжуулагч, бутлагдсан хүдийн агуулах зэрэг тоног төхөөрөмжийг агуулдаг.

Бутлагдсан хүдийн бункер нь 2м x 1м x 1м хэмжээтэй байна. бутлагдсан хүдэр туузан дамжуулагч тээвэрлэгдэн бункерт хийгдэх ба эндээс тээрмийн тэжээгчээр дамжин баяжуулах хэсэгт шилжшинэ.



Баяжуулах хэсэг нь 45 x 29.7м талбай эзэлсэн байгууламж юм. Барилгад 2 шатны тээрэм, ангилах төхөөрөмжүүд, гравитациар баяжуулах төхөөрөмжүүд, гидрометаллургийн боловсруулалтын төхөөрөмжүүд болон ус, булингын шахуурга зэрэг бусад төхөөрөмжүүд байрлана. Барилгын 14 м урттай эхний хэсэгт нунтаглах, ангилах процессын тоног төхөөрөмжүүд, дараагийн 18 м-тэй хэсэгт гравитацийн баяжуулалтын төхөөрөмжүүд болон өтгөрүүлэгч байрлуулсан байна.

Үлдсэн 12.5 м урттай хэсэгт гидрометаллургийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан. Мөн засвар үйлчилгээний зориулалт бүхий талбайтай. Хаягдал болон алт цэвэршүүлэх хэсэг нь барилгын үлдсэн 13 м урттай хэсэгт зэрэгцээ байрладаг. Мөн үүний хэсэгт хаягдлыг саармагжуулах тоног төхөөрөмж бүхий хэсэг байрлаж байна.

1.5.3. Хаягдлын далан

Нарантолгойн ордын нөөц, далд уурхай, баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ордыг ашиглах хугацаанд үндэслэн хаягдлын санд хуримтлагдах хаягдлын нийт эзэлхүүнийг тогтоож баяжуулах үйлдвэрийн технологи, холбогдох дүрэм, шаардлагуудад тулгуурлан хаягдлын шинж чанарыг тодорхойлж хаягдлын далангийн бүтэц, хаягдлыг байршуулах төлөвлөгөөг гаргаж байгаль орчныг хамгаалах арга хэмжээг тодорхойлж гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг төлөвлөсөн.

Нарантолгойн уурхайн баяжуулах үйлдвэрийн баруун аманд байдаг бөгөөд 18 га ашигтай талбайтай 1,0-1,5 сая м³ хаягдлыг хадгалах боломжтой байсан бөгөөд нэмэлт өргөтгөлийн ажлыг 2019 онд шинээр хийж 180,000 тн нэмэгдүүлсэн (Зураг 7. GoogleMapsPro). Уг талбай нь зүүн урагш харсан хонхор уулын аманд байгаа нь салхиар тоос тараагдах боломж бага. Ашиглалтанд аваад 9 жил өнгөрөхөд ан цав хагарал, гадаргийн эвдрэл, цөмрөлт суулт ажиглагдаагүй. Үер, гадаргын уснаас хамгаалах шуудуу, даланг хамгаалсан. Хаягдлыг ул, хананд нэвчих байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс хамгаалж 3 мм-н зузаантай зориулалтын нийлэг материалаар (PVC)-р бүрэн доторлосон.




Зураг 8. Хаягдлын далан

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баяжуулахаас гарсан шаварлаг хаягдлыг $\Phi 5000 \times 5600$ хэмжээтэй тусгай зориулалтын торхонд шингэрүүлж усанд уусган дэвээж хоргүйжүүлэх торхонд хийж уусмал дахь цианийн хэмжээг $0,1 \text{ мг/л}$ болтол бууруулна. Хаягдал дахь цианийн агуулга $0,1 \text{ мг/л}$ болгосноор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнд хүрэх бөгөөд байгаль орчин хүн амьтанд сөрөг нөлөө үзүүлэхгүй аюулгүйн хэмжээнд байна гэж үзэж болно.

Далангийн аюулгүйн хяналт: Хуурай хаягдлын далангын байрлал нь баяжуулах үйлдвэрийн баруун талд оршдог. Далангийн өргөн 500м, урт 600м, ус агуулах талбай 300000 м^2 , далангийн суурийн өндрийн тэмдэглэгээ 1093м, тооцоолсон ашиглах өндрийн хэмжээ 32м, дундаж налуу 5° . Анхдагч даланг хаягдал чулуу болон баяжуулах үйлдвэрийн хөрснөөс гарсан холимог чулуугаар байгуулсан. Үүнд:

- Далангийн суулт, элэгдэл, эвдрэл
- Ус зайлуулах суваг шуудуу
- Усны ба хяналтын цооногын шинжилгээ
- Хаягдлын гадаргуугийн хяналт
- Агаарын тоосны шинжилгээ г.м



Зураг 9. Хаягдлын далангийн схем

- Цэнхэр шугам- ус нэвчих үеийн хязгаар
- Шар шугам- хагарах хүчдэлийн бүс
- Улаан шугам- болзошгүй эвдрэлийн хүрээ

1.5.4. Цахилгаан эрчим хүчний хангамж


Нарантолгойн уурхай нь цахилгаан хангамжийн нэгдсэн системд холбогдсон бөгөөд уурхайн бүх цахилгаан эрчим хүчний хэрэглэгчид нь нэгдсэн системээс хангагдаж байна. Цахилгааны эх үүсвэр нь 2500кВА-ын хүчин чадалтай 110/10кВА-ын дэд станцаас тэжээгдэж байна. Уурхайн цахилгаан эрчим хүчийг дараах байдлаар хангаж ажиллаж байна. Үүнд:

- | | |
|---|----|
| ➤ Худгийг 10/0,4 кВ-ын 100 кВА-ын чадалтай дэд станц | 1ш |
| ➤ Уурхайн хэрэглэгчдийг 200 кВА-ын чадалтай дэд станц | 2ш |
| ➤ 400 кВА-ын дэд станц | 1ш |
| ➤ Баяжуулах үйлдвэрийг 1000 кВА-ын чадалтай дэд станц | 1ш |
| ➤ Ажилчдын байрыг 200 кВА-ын дэд станц | 1ш |




Зураг 10. Уурхайн дэд станц оролтын шугамын хүчин чадал (35000V)

Гадаад цахилгаан хангамж: Нарантолгойн ордоос урагш 3-5 км зайд Борнуур-Цагаанбулагийн 110/35/10 Кв-н өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, Борнуур-Угтаалыг холбосон 35 Кв-ын шугам тус тус дайран өнгөрдөг. Нарантолгойгоос 2 км зайд орших Талбулаг баг нь Жаргалант сумаас эрчим хүчээр хангагдах ба Жаргалант сумаас татсан 10 кВ-н цахилгаан дамжуулах шугам, 10/0.4-н 4 кВА-н дэд станцтай (Зураг 6). Уурхай нь цахилгаан хангамжын нэгдсэн системд холбогдсон ба уурхайн цахилгаан хангамжид зориулсан нийт 5 дэд станц байдаг. Уурхайн цахилгааныг эрчим хүчээр хангахын тул 10 кВ-н шугамууд, 10/0.4 кВ-ын дэд станцуудыг барьсан (Зураг 9).



Зураг 11. Уурхайн гадаад цахилгаан хангамжийн ерөнхий байршил



Зураг 12. Уурхайн дотоод цахилгаан хангамжийн ерөнхий схем

1.5.5. Усан хангамж

Технологийн болон ундны усан хангамжинд гүний 1 худгийг ашигладгаас гадна 3-р босоо ам, хаягдлын даланд тогтсон усыг эргүүлэн ашиглах замаар баяжуулах үйлдвэрийн усны хэрэгцээг хангаж байгаа болно. Гүний худгийн усны ундарга 2.6 л/сек. Технологийн усны гол хэрэглэгч нь баяжуулах үйлдвэр юм.

Баяжуулах үйлдвэр нь нийт хэрэгцээт усны 20 хувийг шинэ усаар, 80%-ийг эргэлтийн усаар ашиглаж байгаа болно. Өдөрт хэрэглэх эргэлтийн усны нийт хэмжээ 1267.8 м³ байх бөгөөд энэ нь нэг тн хүдэр баяжуулалтанд 4.2 м³/тн зарцуулалттай байна. Эргэлтийн усанд нэмж оруулах цэвэр усны хэмжээ 20% байх бөгөөд цэвэр усны зарцуулалт 0.71 м³/тн байна. Баяжуулах үйлдвэрт өдөрт дунджаар 300 тн хүдэр баяжуулах бөгөөд өдөрт шаардлагатай цэвэр усны хэмжээ 214.2 м³ байна. Энэ нь цагт 8.9 м³/цаг буюу 2.4 л/сек ундарга шаардана.



Зураг 13. Ахуйн болон технологийн хэрэглээний гүний худаг

1.5.6. Химийн бодисын агуулах

“Тэн Хун” ХХК-ны үйл ажиллагаанд ашиглагдаж буй химийн бодисуудыг “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” MNS 6458:2014 стандартын дагуу ангилах, хадгалах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Тус компанийн баяжуулах үйлдвэрлэлд Монгол улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан Монгол улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад багтдаг натрийн цианидыг тусгай зөвшөөрлөөр ашиглагддаг бөгөөд Нарантолгойн уурхайн баяжуулах үйлдвэрийн зүүн урд талд 270 метр зайд стандартын зайн хэмжээн дагуу цианит натрийн төв агуулах байрлаж байна. Агуулахын хашааны дотор хашааг тойрсон шуудуу бүхий усны хамгаалалттай ба цооногоос ус татах насостой. Мөн галын аюулаас хамгаалах хэрэгслийн сараатай. Галын хор болон бусад багаж хэрэгсэл бүрэн байгаа болно. Хашааны гадна 55 метрийн зайд харуулын байртай. Цементэн талбайтай, төмөр торон хашаатай, хамгаалалтын өргөст тортой.

“Тэн Хун” ХХК алтны хүдэр боловсруулах үйлдвэрийн зүүн урд талд 270 метр стандартын зайд цианид натрийн төв агуулах байрладаг. Цианид натрийн агуулах нь 22 тн 11 ширхэг контейнерээс бүрдэнэ. Контейнер тус бүр нь 2 цоож болон лацтай. 24 цагын турш хяналтын 2 камер, хөдөлгөөн мэдрэгч дохиололтой, харуул хамгаалалтын байнгын нэг хамгаалагч хяналт тавин ажилладаг. Өдөрт 2 удаа холбогдох ажилчид шалгалт хийж тэмдэглэл хөтөлдөг байна. 2 тод гэрэлтүүлэгтэй, хашааны дээгүүр өргөст тороор хамгаалагдсан, лацадсан цоожтой байдаг. Агуулахын хашааны дотор хашааг тойрсон шуудуу бүхий усны хамгаалалттай ба цооногоос ус татах насостой. Мөн галын аюулаас хамгаалах хэрэгслийн сараатай. Галын хор болон бусад багаж хэрэгсэл бүрэн байгаа болно. Хашааны гадна 55 м зайд харуулын байртай. Цианид натрийн нөөцийн агуулахын суурь талбай нь 30 м урт, 25 м өргөн, нийт 750 м² талбайг 30 см зузаан цементэлж байгуулсан байна.



Зураг 14. Химийн бодисын агуулах

1.5.7. Баяжуулах үйлдвэрийн лаборатори

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа болон баяжуулах үйлдвэрийн технологийн шат дамжлага бүрд хяналт тавих зорилгоор баяжуулах үйлдвэрийн дэргэд шинжилгээний лаборатори ажиллаж байна.

Лаборатори дараах үндсэн үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- Хүдрийн найрлагыг судлах
- Хүдэр дэх металлын агуулгыг тодорхойлох
- Технологийн шат дамжлага бүрийн бүтээгдэхүүнүүдэд шинжилгээ хийж чанарын хяналт тавих
- Технологид хэрэглаж байгаа усны болон уусмалын агуулгыг хянах
- Хаягдал дахь хорт бодисын хэмжээнд хяналт тавих

Дээрх үйл ажиллагааг явуулахын тулд баяжуулах үйлдвэрийн шинжилгээний лаборатори нь дараах нэгж хэсгүүдээс бүрдэнэ.

- Дээж авч шинжилгээнд бэлтгэх хэсэг
- Металл хайлуулах цех
- Хими, спекторийн шинжилгээний хэсэг

Лабораторийн үйл ажиллагаа үйлдвэрийн үйл ажиллагаантай зэрэгцээ явагддаг.



Зураг 15. Баяжуулах үйлдвэрийн лаборатори

1.5.8. Техникийн засвар үйлчилгээний барилга байгууламж

Уурхайн засварын үйлчилгээний дэд бүтэц нь уулын механик тоног төхөөрөмж, байжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийхийн зэрэгцээ засвар ашиглалтын хэрэгцээний төрөл бүрийн материал, сэлбэг хэрэгсэл, түлш, тос зэргийг хүлээн авч хадгалах, тавьж олгох зориулалттай.

Ашиглалтын үйлчилгээний өндөр түвшин, материал техникийн хангамжийн найдвартай системээр уурхайд ажиллаж буй бүх тоног төхөөрөмжийн хэвийн ашиглалтыг хангахад үндэслэн засвар техникийн үйлчилгээний ажлын хэмжээг тооцно. Уурхайн засвар техникийн үйлчилгээний дэд бүтцийн зориулалт, зохион байгуулалтын схем боловсруулалт, гарсан тооцооны дагуу дор дурьдсан бүтцийг төсөлд сонгож авсан болно. Үүнд:

1. Уулын механик тоног төхөөрөмжийн агрегатын засварын хэсэг, зөөврийн засвар техникийн үйлчилгээний бригадын хамт
2. Автомашины агрегатын засвар техникийн үйлчилгээний хэсэг
3. Механик цех
4. Цахилгаан тоноглолын засварын хэсэг
5. Материал сэлбэгийн агуулах
6. Автомашины гараж



Зураг 16. Техникийн засвар, үйлчилгээний барилга

1.5.9. Тэсрэх материалын агуулах

Тэсрэх материалын агуулах нь тэсрэх бодисын, тэсрэх хэрэгслийн, түгээх байр, харуулын байр гэсэн нийт 4 барилгатай.

Тэсрэх материалын агуулах нь уурхайн тэсэлгээний ажилд шаардагдах тэсрэх материалыг хадгалах, түгээх үндсэн үйл ажиллагаатай. Уурхайн тэсрэх материалын агуулахын онцгой хамгаалалтын барилга байгууламжийг 2009 онд барьж ашиглалтанд оруулсан. Тус агуулахад харуул хамгаалалтын 2 ажилтан, агуулахын нярав 2 ажилтан ажиллаж хамгаалдаг. Тэсрэх материалын агуулах нь Нарантолгойн уурхайн лицензийн талбай дотор шороон далангаар хамгаалсан хагас далд хэлбэртэй блокоор барьж шавардсан. Агуулахын талбайг бүрэн гэрэлтүүлэхээр тал бүрээс нь 5 ширхэг гэрэлтүүлгээр гэрэлтүүлсэн. Галын цэг болон гал унтраах хэрэгслээр тоноглогдсон. Тэсрэх материалын агуулахын багтаамж нь 20 тн юм.

Тэсрэх материалын агуулахын нутаг дэвсгэрийн зориулалтын талбайд цэнэглэгч машинд болон тэсрэх бодис бэлтгэж үйлдвэрлэх суурин цэгт тэсрэх бодис 2 хоногоос илүүгүй хугацаагаар хадгалахыг зөвшөөрнө. Уурхайн их ам болон налуу малталтын гүнзгийрэлтийн үед тухайн ээлжинд хэрэглэх тэсрэх материалыг эдгээр малталтын амнаас 50 м-ээс багагүй зайд тусгайлан бэлтгэсэн байранд хадгална.



Зураг 17. Тэсрэх материалын агуулах

1.5.10. Түлшний агуулах ба шатахуун түгээх станц (ШТС)

Шатахуун цэнэглэх станцын ажлын зургийг Монгол улсын стандарт MNS 4628 98-ийн зааврыг баримтлан 2009 оны 4-р сард “АКСИОМ констракшн” ХХК-нд доорх байгаль цаг уурын нөхцөлд тохируулан боловсруулан гүйцэтгэсэн. Үүнд:

Гадны агаарын температур 34.3 градус

Салхины хүч 35 кг/м.кв

Цасны ачаалал 50 кг/м.кв

Шатахуун цэнэглэх станцын В20 маркийн бетон хучилттай тавцанг зүүн тийш конторын барилгатай зэрэгцээ /створ/, авто замаас 15 м-ийн зайд байрлуулсан. Орох замын эхэн дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг хязгаарласан замын тэмдэг болон галын аюултай бүсийг анхааруулсан тэмдгийг байрлуулсан.



Зураг 18. Шатахуун түгээх станц

1.6. “Тэн Хун” ХХК-ний байгаль орчны үнэлгээ, холбогдох зөвшөөрлүүд

1.6.1. “Тэн Хун” ХХК-ны эзэмшдэг тусгай зөвшөөрөл

Хүснэгт 3. “Тэн Хун” ХХК-ийн эзэмшдэг ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Дугаар	Хүчинтэй хугацаа
А. Ашигт малтмал олборлох ашиглалтын тусгай зөвшөөрөл			
1	Нарантолгой ордоос ашигт малтмал ашиглахыг тусгай зөвшөөрөл	MV-000713	2007.01.23-30 жил

1.6.2. Газар ашиглах зөвшөөрөл, гэрчилгээ

Хүснэгт 4. Газар ашиглалтын зөвшөөрөл, гэрчилгээ

№	Газар эзэмших зориулалт	Гэрчилгээний дугаар	Газрын хэмжээ м/кв	Хүчинтэй хугацаа
1	Уул уурхайн үйлдвэрийн барилга, байгууламж	0000104232	19984	2022.07.04-2027.07.07
2	Нөөц газар	600104227	3737683	2022.07.04-2027.07.04

1.6.3. Байгаль орчны холбогдох зөвшөөрөл

Хүснэгт 5. Байгаль орчны холбогдох зөвшөөрөл, хүчинтэй хугацаа

№	Газар эзэмших зориулалт	Дугаар	Хүчинтэй хугацаа
1.	Химийн бодис ашиглах зөвшөөрөл	0002622	2024.01.22-2029.01.22
2.	Химийн бодис ашиглах зөвшөөрөл	0001836	2021.03.29-2024.12.31
3.	Ус ашиглуулах дүгнэлт	E-2405-000002	2024.12.31
4.	Ус ашиглах зөвшөөрөл	A/08	2024.12.31
5.	Галын аюулгүй байдлын дүгнэлт уул уурхай олборлолт	0019332	2024.10.08-2026.10.08
6.	Шатах, тослох материал түгээх	0003698	2024.12.11-2025.12.11
7.	Тэсрэх бодисын агуулах	0003699	2024.12.11-2025.12.11

1.6.4. Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тайлан

Нарантолгой уурхай 2019 оноос 2024 хүртэл “Их Зос” ХХК-иар төслийн талбайн орчны хяналт шинжилгээний мониторингийг жилд 2 удаа гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөр уурхайн үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчинд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг жилүүдийн хооронд тодруулах, тухайн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулж, уг зөвлөмжийн дагуу арга хэмжээ авахад оршино.

1.7. Уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, нийт зардал

Нарантолгойн уурхайн MV-000713 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдана. Уурхайн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндсэн олборлох, баяжуулах үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг нэгтгэсэн болно. 2025 оны байгаль орчны төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн ажлын зардалд нийт ерөн нэгэн сая есөн зуун дөчин мянган (**91,100,000**) төгрөг төлөвлөсөн байна.


2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төв аймаг нь Монгол улсын нутгийн төв хэсэгт Хэнтий уулархаг Дорнод Монголын талархаг мужид 77.4 мянган дөрвөлжин км газар нутагтай, 27 сум, 97 багтай. Тус аймаг нь 94.8 мянган хүн ам, 27 мянган айл өрхтэй. Аймгийн төв Зуунмод хот нь нийслэл Улаанбаатар хотоос 43 км зайтай. Дэд бүтцийн хувьд аймгийн нутаг дэвсгэрт Монгол улсын нийслэл Улаанбаатар хот байрладаг, харилцаа холбоо, авто, төмөр зам зэрэг үйлдвэрлэлийн дэд бүтэц харьцангуй сайтай. Аймгийн хэмжээнд 2020 оны 1-р улиралд 5.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлвэрлэсэн нь 2019 оны мөн үеэс 3.6 хувь буюу 0.2 тэрбум төгрөгөөр өссөн. Аймгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт өмнөх оноос 15.5 хувь буюу 0.3 тэрбум төгрөгөөр өссөнөөс харагдаж байна.

Төв аймгийн Жаргалант сум нь 186.6 мян.га газар нутагтай, Зуунмод сумаас 180 км, Улаанбаатар хотоос баруун хойш 135 км, урд талаараа Төв аймгийн Баянцогт, Угтаалцайдам сум, зүүн талаараа Төв аймгийн Борнуур сум, хойд талаараа Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Төв аймгийн Сүмбэр сум, баруун талаараа Төв аймгийн Цээл, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумуудтай хиллэдэг. Засаг захиргааны анхан шатны нэгж 4 баг, 6568 гаруй хүн ам, 95.41 мянга гаруй толгой мал, 1798 айл өрхтэй. Ордыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар, улс орон нутгийн экспортын орлого нэмэгдэхээс гадна уурхай болон уурхайг дагалда тухайн бүс нутагт ханган нийлүүлэгч, үйлчилгээ, жижиг дунд ажлын байр бий болж, орон нутагт ажил эрхлэлт нэмэгдэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, шинээр хүн амын төвлөрөл бий болох зэрэг олон зэрэг нөхцөл бүрдэх болно.

2.1. Уур амьсгал


Эх газрын эрс тэс уур амьсгалтай, агаарын температурын хоногийн хэлбэлзэл нэлээд өндөр (хавар, намар). Өвлийн улирал нь хахир, хүйтэн, 11-р сараас 3-р сар хүртэл харьцангуй удаан үргэлжилнэ. Хамгийн их хүйтэн нь 1-р сард -48°C -д хүрнэ. Тогтвортой цасан бүрхүүл 11-р сарын дундаас 3-р сарыг дуустал үргэлжилдэг. Хөрсний хөлдөлт 9-р сарын дундаас 5-р сарын сүүлч хүртэл үргэлжлэх бөгөөд гүн нь өвөлдөө 3.0 м хүрэх боловч мөнх цэвдэг байхгүй. Хаврын улирал 3-р сарын сүүлчээс 6-р сарын эхэн хүртэл үргэлжлэх ба хоногийн температурын хэлбэлзэл ихтэй, агаарын хуурайшилт их, хүчтэй салхитай байдаг. Зун нь бусад улирлаас арай богино, агаарын хамгийн их халуун 7-р сард нэмэх $19-26^{\circ}\text{C}$ -д хүрнэ. Жилд орох хур тунадасны хэмжээ 300-400 мм, түүний 60-80% нь 7, 8-р саруудад унадаг бөгөөд хур тунадастай өдрийн тоо жилд дунджаар 60 хоног. Салхины дундаж хурд 4-8 м/сек, голдуу баруун-хойд, хойд, зүүн-хойд зүгээс салхилах бөгөөд заримдаа 20-22 м/сек хүрдэг.



Зураг 19. Цаг уурын ОЖД мэдээ, Жаргалант сумын цаг уурын харуулын мэдээ

2.2. Хөрс, ургамал зүй

Нарантолгойн ордын талбай нь уул тал хосолсон нутаг учраас энэ нөхцөл зохицсон ургамал амьтны аймаг тархжээ. Тал хөндий, уул бэл хормой нь үржил шим сайтай учир хадлан, тариалан эрхлэх, төмс, хүнсний ногоо тариалах гол эх үүсвэр нь болдог. Нутгийн уулархаг хэсгийг дөрвөн улирлын эргэлтэд бэлчээрт ашиглана. Баянцогт, Нарантолгой, Хуштын нурууны ар хажуугаар бага зэргийн талбайд ой мод ургана. Ой модны бүрэлдэхүүнд нарс, хус, улиас, бургас, нохойн хошууны бут зонхилдог.



Зураг 20. Монгол орны хөрсний зураг

2.3. Ус зүй

Усан сүлжээ нь Хойд мөсөн далайн ай савд багтах ба талбайн баруун хэсгээр Жаргалантын тогтмол урсацтай гол урсаж Загдалын голд цутгадаг. Загдалын гол нь Хараагийн голд цугтана.

2.4. Ан амьтан

Ан амьтдаас голдуу үнэг, чоно, гөрөөс, буга, бодон гахай, тарвага зурам, байгаагийн зэрэгцээ олон тооны жигүүртэн шувууд амьдардаг. Мөн төрөл бүрийн шавж, хоёр нутагтан, мөлхөгчид элбэг.

2.5. Ордын геологийн тогтоц

Нарантолгойн орд нь геологийн тогтцын хувьд Хараагийн групп зузаалгийн элсэн чулуу-занар ба Бороо голын бүрдлийн 2-р фазын боржин диоритын шток, тэдгээрийг зүссэн хазаарын бүрдлийн диорит порфирит, кварцын порфир, жижиг ширхэгтэй боржингийн дэл судлууд, кварцын судлууд зэргээс тогтдог.

Хараа группийн доод зузаалаг болох Ширгүү формафийн хурдас нь Нарантолгойн ордын орчимд тархсан. Чулуулаг нь голчлон зүүн хойш чиглэлтэй сунаж тогтох ба унал нь баруун хойш болон зүүн урагшаа босоодуу 60-80 хэмийн уналттай байх бөгөөд дотроо ногоовтор саарал өнгөтэй элсжин ба алевролитын үеүд нь ээлжлэн үелсэн флиш тогтоцтой ба бичил атираанд орсон байна.


Эдгээр тунамал чулуулаг нь боржин диориттэй хиллэх хэсэгт хүчтэй роговикжсэн байдаг. Талбайн урьд хэсэгт тас хар өнгөтэй кварцитын үе /лидитийн/ тохиолдоно.

Талбайн хэмжээнд тархсан Нарантолгойн шток бүхий жижиг интрузив чулуулаг болох боржин диоритыг БНАГУ-ын геологичид кали-аргоны аргаар тогтоосон радиологийн нас нь 215-210 сая жил (Кампе. А, №975) буюу дээд триасын түвшинг заадаг гэж тогтоосон.

Б. Пүрэвсүрэн нар 1984-1988 онуудад хийсэн 1:150000-ын масштабын геологийн зураглалын ажлаар дүүргийн хэмжээнд түгээмэл тархалттай Ордовикийн настай Бороо голын интрузив нас нь маргаантай байгаа юм. Бид Б. Пүрэвсүрэн нарын тэмдэглэснээр Ородовикийн настай боржин диоритийн тэмдэглэгээг авч ашиглалаа.

Энэ чулуулаг нь хайгуулын талбайн баруун, баруун өмнөд хэсгээр тархсан бөгөөд харин 1-р фазын диорит нь боржин диоритийг зүссэн байдлаар тохиолдохоос гадна талбайн баруун өмнөд хэсэгт кварцын судлуудын адил /Бороогийн орд шиг/ хэвтээ байрлалтай тохиолддог. Хараагийн группийн чулуулаг болон гранодиоритын биетүүд нь диорит, кварц-порфир болон аплит, пегматитын дэл судлууд болон алт агуулсан кварцын судлаар зүсэгдсэн байна.

Нарантолгойн боржин диоритын шток нь 3.0 км х1.5 км хэмжээтэйгээр хойд зүгт сунасан, зууван хэлбэртэй тогтсон байдаг.



Зураг 21. Ордын геологийн зураг

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Нарантолгой төслөөс алтыг далд аргаар олборлох төслийн БОНБНҮ-ээр төслийн гол болон болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

3.1. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

БОННҮ болон компанийн дотоод бичиг баримт болох Агаар мандалд ялгарах бохирдлын удирдлагын төлөвлөгөөнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал: уурын зуух, хүнд машин механизм, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, баяжуулах үйлдвэр зэргээс агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй. Эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Агаар орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, машин техникийн хөдөлгүүрээс гарах хүхэрлэг хий, азотын давхар исэл зэрэг бусад хорт хий болно.

Агаарын орчинд их хэмжээний тоосжилт үүссэнээр нарийн тоос ургамлын тоос хүртэлтэд сөргөөр нөлөөлж байгалийн аясаар үрээр нөхөн сэргэх үйл явцыг сааруулна. Мөн уурхайн орчинд ажиллаж байгаа ажилчид, нутгийн оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж ая тух алдагдуулах сөрөг үр дагавартай. Тиймээс агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Дараах болзошгүй нөлөөллүүдийг тодорхойлох, холбогдох арга хэмжээнүүдийг төлөвлөөд байна. Үүнд:

- Агаарын орчны бохирдлын хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давахгүй, хамрах хүрээ нь бага байх боловч олборлолтын үйл ажиллагаанаас гадна уур амьсгалын ерөнхий өөрчлөлт байгалийн салхины үйлчлэлээр орчны тоосжилт их байх тохиолдлууд байна. Энэ нь тэр орчмын хүн, амьтан, ургамал сөрөг нөлөөлөх
- Уурын зуухны шаталтын үйл явцын дүнд СО (нүүрстөрөгчийн дутуу исэл), НС (нүүрс ус), Nох (нитрат, нитрит), SO₂ (хүхрийн оксид) болон тоосжилт ялгарч агаарын чанарт муугаар нөлөөлөх
- Баяжуулах үйлдвэр болон лабораторийн улмаас дотоод орчны агаарт химийн бодисын нарийн тоосонцор хий тархаж болзошгүй тул дээрх газруудад агаар солилцуулан бүрэн агааржуулах буюу хэсэгчлэн агаар зайлуулах системийг суурилуулах
- Салхины хурд 8-10 м/с байхад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр замаас үүссэн тоосны тархалт эсвэл суларсан шороотой газруудаас тоос үүсэх
- Ачиж буулгахад ажиллах хүнд даацын машины нөлөөллөөр их хэмжээний сул шороо дэгдэж, агаарт байх нарийн ширхэгтэй тоосонцорын агууламж нэмэгдэх, үүссэн тоосжилт, хорт хий газарт бууж ургамлан бүрхэвч хөрсөнд нөлөөлөх
- Машин техникийн хөдөлгөөн, тэсэлгээ, бутлах цехийн дуу шуугианы хэмжилтийг хийхэд генераторийн дэргэд, бутлах хэсгийн ойролцоо зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлттэй байгаа нь тухайн орчинд ажиллах ажилтны эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх.

- Шимт хөрсний овоолгыг (MNS 5916:2008) стандартын дагуу зөв хэлбэртэй хийж ургамалжуулснаар тоосжилтыг сааруулах мөн хөрсний үржил шимийг хадгалан сайжруулах
- Уурхайн дотоод замыг засаж сайжруулах, замыг байнга усалж чийгшүүлэх, барьцагдуулагч шингэн ашиглаж тоос босох гадаргууг шүрших зэрэг аргыг ашиглах.

3.2. Хөрсөнд учирч болзошгүй нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээ

Уурхайн ашиглалтын явцад олборлолт болоод барилга байгууламж, зам талбайд нийтдээ 11.7 га талбай эвдрэлд өртсөн байна. Эдгээр байгууламжуудыг барих явцад хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөөллүүд шууд учирсан байж болзошгүй. Тиймээс хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

- Уурхайн үйл ажиллагаанаас их хэмжээний талбайн хөрс эвдрэлд орж, хөрсний бүтэц, шинж чанар нь алдагдана.
- Зам, талбайн хөрс нэлэнхүйдээ эвдрэлд орж хөрсний бүтэцэд өөрчлөлт орно.
- Өнгөн хөрс хуулах, хадгалах явцад салхи, шуурганы нөлөөгөөр өнгөн хөрсний тодорхой хэсэг алдагдах нөхцөлтэй.
- Түүнчлэн шингэн, хатуу хог хаягдал, шатах, тослох материалаар хөрс бохирдож болзошгүй юм.
- Уурхайн карьер, овоолго, барилга байгууламж, авто зам үүсэх талбайн шимт хөрсийг 30 см зузаантай хуулж “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” (MNS 5916:2008) стандартыг мөрдлөг болгон ажиллах.
- Авто засварын газар, авто машины зогсоол, шатах, тослох материалын агуулах, түгээгүүр орчмын хөрс нефть бүтээгдэхүүнээр бохирдож болзошгүй эрсдэл өндөр тул шимт хөрсний хуулалт хийж, тухайн талбайг шаварлаг хурдсаар хучих, хатуу хучилттай болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.
- Ажилчдын нийтийн бие засах газар, хоол хүнсний хаягдал, ахуйн хэрэглээ удаан задардаг органик нэгдэл (угаалгын бодис) зэргээр хөрс бохирдох эрсдэлтэй тул хөрсөнд үл нэвчих материалаар жорлон болон ахуйн хог хаягдлын цэгийн доторлох шаардлагатай ба хөрс бохирдуулагч бодисын стандартыг (MNS 5916:2008) мөрдөж ажиллах шаардлагатай.

3.3. Ургамал, амьтанд учирч болзошгүй нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээ

Төслийн талбай орчимд машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, хөрсний шороо суларснаар ургамлын нөмрөг элэгдэл эвдрэлд өртөж болзошгүй сөрөг нөлөөтэй. Төслийн талбайд зориулалтын явган замтай болгох, тээврийн хэрэгслийг тусгай тэмдэг, шон байршуулсан замаар зорчуулах, авто зам болон нүүрсний тоос их бужигнах газрыг услах тоос үүсэлтийг сааруулах, кемпийн барилга байгууламж хоорондуур байрлах хөрс гадаргуугийн ургамлын нөмрөгийг талхалж гишгэхгүй, усалж тордох, нэмэлт олон настын үр суулгаж зүлэгжүүлэх арга хэмжээнүүдийг авч байх.

Тухайн орчинд амьдарч байгаа ан амьны байршил, тоо толгойг тогтоон олборлолтын ажиллагаанаас учрах сөрөг нөлөөллийг тогтоож багасгах, арилгах арга хэмжээ авахаас гадна төслийн явцад ургамал ан амьтанд нөлөөлөх нөлөөллийн хяналтыг явуулна. Төслийн үйл ажиллагаанаас гарах үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу хог хаягдлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу байгаль орчинд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй байх талаас анхааран арга хэмжээ авч хогийг зайлуулах.

3.4. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Далд уурхайн цаашдын ашиглалтаар нэвтрэх малталтаас гарах хоосон чулуулгийн өмнө нь байсан хөрсний гадаад овоолгуудыг өндөрлөн хураах тул шинээр талбай эвдрэхгүй байхаар тооцлоо. Уурхайн одоогийн байдлаар далд уурхай, овоолго, далан, баяжуулах үйлдвэр, шимт хөрс, бусад барилга байгууламжуудад нийт 11.7 га талбай эвдрэлд өртсөн байна.

Уурхайн цаашдын ашиглалтаар нэмж шимт хөрс хуулахгүй учир өмнөх жилүүдэд хуулж, овоолсон шимт хөрсөөр биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго, зорилт: Нарантолгойн уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа “Саблейм” ХХК-иар 2022 онд боловсруулсан Нарантолгойн алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах, цианитаар уусган баяжуулах төслийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол тайлан, 2023 онд “Мон Газар Консалтинг” ХХК-ийн боловсруулсан Нарантолгойн алтны үндсэн ордыг далд аргаар олборлох, боловсруулах төслийн Байгаль орчны аудитын тайлан, 2024 онд Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвөөс Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг судлах, судалгааны үр дүнд үндэслэн гарч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах зорилгоор хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын тайлан, зөвлөмжийн дагуу төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заагдсан бүтэц, агуулга аргачлалын дагуу боловсруулав.

Хамрах хүрээ: Нарантолгойн уурхайн MV-000713 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдаж байгаа үндсэн олборлолтын үйл ажиллагаа БОННУ-г холбогдох хууль, журмын дагуу БОАЖЯ-аар батлуулсан. Уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндсэн олборлох, баяжуулах үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг нэгтгэсэн болно.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Агаар орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, машин техникийн хөдөлгүүрээс гарах хүхэрлэг хий, азотын давхар исэл зэрэг бусад хорт хий болно. Агаарын орчинд их хэмжээний тоосжилт үүссэнээр нарийн тоос ургамлын тоос хүртэлтэд сөргөөр нөлөөж байгалийн аясаар үрээр нөхөн сэргэх үйл явцыг сааруулна. Мөн уурхайн орчинд ажиллаж байгаа ажилчид, нутгийн оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж ая тух алдагдуулах сөрөг үр дагавартай.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон компанийн дотоод бичиг баримт болох Агаар мандалд ялгарах бохирдлын удирдлагын төлөвлөгөөнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал: хүнд машин механизм, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хүдрийн болон хаягдал чулуулгын овоолгууд, ил уурхай, тэсэлгээ, дулааны төв станц, түлшний хэрэглээ зэргээс агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй. Эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 6. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Хаврын шар ус, бороо, цас, хөрсний гэсэлтэнд зам талбай эвдрэх	Зам талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засах	Уурхайн бүхий л үйл ажиллагаанд	-	-	Шаардлагатай үед	Агаарын тухайн хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2.	Техникийн хорт хий ялгарах	Ашиглалтын уурын зуухнууд, цахилгаан хангамжийн үүсгүүрээс яндангаас гарах хорт хийд тогтмол хяналт тавих, сайн чанарын түлш хэрэглэх	Агаарын орчинд	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан		Өдөр бүр	MNS 4585:2016 “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин” MNS 5002:2000 /Гадаад орчны шуугианы зөвшөөрөгдөх
3.		Уурхайн бүх тээврийн хэрэгслийн яндангаас гарах хорт хийд тогтмол хяналт тавих, сайн чанарын түлш хэрэглэх		600.0		Төсөл хэрэгжих хугацаанд	
4.		Машин техникийн засвар үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд тогтмол хийх		-	-	Шаардлагатай үед	

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.		Уурхайн бүх тээврийн хэрэгслийн агаарт гаргах хаягдал ноогдуулах төлбөрийг төлөх			ҮАЗ	Хуваарьт хугацаанд	түвшин/ Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага стандартууд
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
6.	Орчны тоосжилт үүсэх	Шороон зам дээр тээвэр хийх үед хүнд даацын машины хурдыг хязгаарлах, тэмдэглэгээ тавих	Уурхайн ажилчид	-	ҮАЗ	Тогтмол	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөний шаардлага
7.		Хуурайшилт, тоосжилт ихтэй үед уурхайн гол зам, талбайг усалж тоосжилтыг бууруулах	Байгаль орчны хэлтэс	Усны төлбөрт тусгасан		Төсөл хэрэгжих хугацаанд	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөний шаардлага
Дүн					600.0		

5.2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Тэн Хун” ХХК-ийн явцын болон хаалтын нөхөн сэргээлтэд чухал ач холбогдол бүхий шимт болон шимэрхэг хөрсийг хамгаалах бодлого нь Монгол Улсын холбогдох стандарт (MNS 5916:2008) болон шимт, шимэрхэг хөрсийг зөв хуулах, хадгалах, чанарын үзүүлэлтүүдийг хянах зэрэгт тавигдах шаардлагуудыг тусгасан байдаг.

Төслийн талбай орчимд машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, хөрсний шороо суларснаар ургамлын нөмрөг элэгдэл эвдрэлд өртөж болзошгүй сөрөг нөлөөтэй. Төслийн талбайд зориулалтын явган замтай болгох, тээврийн хэрэгслийг тусгай тэмдэг, шан байршуулсан замаар зорчуулах, авто зам болон нүүрсний тоос их бужигнах газрыг услах тоос үүсэлтийг сааруулах, кемпийн барилга байгууламж хоорондуур байрлах хөрс гадаргуугийн ургамлын нөмрөгийг талхалж гишгэхгүй, усалж тордох, нэмэлт олон настын үр суулгаж зүлэгжүүлэх арга хэмжээнүүдийг авна.

Өмнөх бүлэгт дурьдсан менежментийн төлөвлөгөөний чухал хэсэг болох ургамлан нөмрөгийн судалгаа, хамгааллын асуудлууд нь ургамлын хяналт шинжилгээний журмуудаар зохицуулагддаг. Ирэх 2025 онд ургамал хамгааллын хүрээнд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн хэд хэдэн ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрсний бохирдлын гол үзүүлэлт болох хүнд металлууд нь задарч алга болдоггүй хөрсөнд удаан хугацаагаар хуримтлагдаж ус болон ургамлаар дамжин хүн, мал, амьны бие организмыг молекулын ба гений түвшинд хордуулдаг. Хөрсөн дэх хүнд металлын агууламжийг “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019 стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үнэлнэ. Хөрсний механик бүрэлдэхүүн буюу ширхгийн бүрэлдэхүүнээс хөрсний физик, хими, биологийн олон шинж чанар хамаардаг чухал үзүүлэлт юм.

Хүснэгт 7. Хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Хөрсний үржил шим алдагдах	Шимт хөрсний овоолгыг ургамалжуулах, нөхөн сэргээлтэнд ашиглах	Шимт хөрсний овоолгод	Нөхөн сэргээлтийн зардалд орсон	-	Төсөл хэрэгжих хугацаанд	MNS 5916:2008 стандартын дагуу
2.		Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хориглох, тогтсон маршрутаар зорчуулах	Уурхайн хэмжээнд		-	Тогтмол	
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3.	Уурхайн үйл ажиллагааны улмаас газрын гадарга эвдэрч хөрсөн бүрхэвч устах	Уурхаайн технологийн дотоод тээвэрлэлт, үйлчилгээний зориулалтын тээврийн хэрэгсэлийн зорчих сайжруулсан зам, талбайг иж бүрэн тэмдэгжүүлэн, тээврийн хэрэгсэл, уулын машин механизмын хөдөлгөөнийг заасан маршрутаар хязгаарлах	Уурхайн талбайд	-	ҮАЗ	Тогтмол	Монгол Улсын холбогдох журам MNS 5916:2008
4.		Ургамлын анатоми, физиологийн шинж чанарын судалгааг хийх, ургамлыг бүртгэлжүүлэх	Ургамлын судалгаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	500.0	Төсөл хэрэгжих хугацаанд	Монгол Улсын холбогдох журам
6.	Ахуйн хаягдал, шатах, тослох материал алдагдах, баяжуулах	Ахуйн хог хаягдлыг өдөр бүр авч зайлуулах, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, хяналт тавих	Хогийн цэгийн орчимд	100.0	500.0	Төсөл хэрэгжих хугацаанд	Монгол Улсын холбогдох журам

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	үйлдвэрийн хаягдлыг зайлуулах үед хөрс бохирдох						
7.	Химийн бодисын сав баглаа боодлын хаягдал	Ашигласан химийн бодисын сав баглаа боодлыг ашиглалтын дараа цуглуулж химийн бодисын нийлүүлэгчид буцаан тушаах, эрх бүхий байгууллагын зааврын дагуу аюулгүй газарт хадгалах	Уурхайн талбайд	Хог хаягдлын менежментийн зардал	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Аюултай хог хаягдлын тухайн хууль
Дүн					1 000.0		

5.3. Усны нөөц, чанарын асуудал

“Тэн Хун” ХХК-ийн усны менежментийн бодлогын хүрээнд уурхайн бүх үйл ажиллагаанд усыг зөв зохистой хэмнэлттэй хэрэглэх, усны хэрэглээг хамгийн бага түвшинд хүргэх, усны дахин ашиглалтыг 80%-иас дээш байлгах, мөн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутгийн иргэдийн хэрэглээний усны нөөц, чанарыг хэвээр хадгалахыг зорин ажилладаг.

Уурхайн зүгээс усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалх зорилгын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөөд байна.

Хүснэгт 8. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Унд ахуйн болон үйлдвэрийн зориулалтаар усыг хэмжээгээр ашигласнаар үүсэх нөлөөлөл	Жил бүр ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргуулах	Усан хангамж	-	-	Тогтмол	“Усны тухай хууль”, “Усан орчны чанарын үзүүлэлт”, Хүрээлэн буй орчин, аюулгүй байдал. Ундны ус
2.		Төслийн хэрэгцээг хангах усны эх үүсвэрт баталгаажуулсан тоолуурын бүрэн бүтэн байдлыг хангах, тоолуур баталгаажуулах	Уурхайн талбайн хэмжээнд	-	-	2025	Усны тухай хууль болон бусад дүрэм, журам, стандартууд

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.		Далд амны шавхалтын усыг үйлдвэрийн эргэлтэнд ашиглах	Уурхайн олборлолтын ам, БҮ	ҮАЗ	-	2025	Усны тухай хууль болон бусад дүрэм, журам, стандартууд
4.	Үерийн урсацаас болж гадаргын ус бохирдох	Усыг хэмнэлттэй ашиглах арга технологийг ажилчдын кэмп, оффис, хөрс, ургамалжилтын усалгаанд тогтмол хэрэгжүүлэх	Уурхайн талбайд	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Усны тухай хууль болон бусад дүрэм, журам, стандартууд
5.		Уурхайн ажилтан, ажиллагсдад болон зочдод усны нөөцийг арвилан хэмнэх талаар мэдээлэл тогтмол хийж, хяналт тавьж ажиллах	Үйл ажиллагааны турш	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Байгууллагын дотоод дүрэм, журам
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
6.	Газрын доорх усны чанар, найрлагад сөрөг өөрчлөлт	Ашиглалтын худгийн түвшнийг тогтмол хэмжих	Гүний худаг	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Байгууллагын дотоод дүрэм, журам
7.	Химийн бодисоор гүний ус бохирдох	Хаягдлын далангаас тогтмол шинжилгээ хийж, хяналт тавих	Хаягдлын далан	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Усны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль
8.	Хаягдал усанд тогтоосон цэгүүдээс улирал бүр шинжилгээ хийх	Уурхайн үйл ажиллагааны улмаас гарсан хаягдал усанд тогтоосон цэгүүдэд хяналтын шинжилгээг тогтмол улирал бүр хийж улсын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх	Хаягдал усанд тогтоосон цэгүүдэд	ҮАЗ	500.0	Улирал бүр	Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015
9.	Ус бохирдуулсны төлбөрийг тооцуулах	Улсын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн шинжилгээний хариуг холбогдох бичиг баримтыг “Усны Газар”-г хүргүүлж улирал бүр ус бохирдуулсаны төлбөр тооцуулах	Хаягдал усанд тогтоосон цэгүүдэд	ҮАЗ	-	Улирал бүр	Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

10.	Усны тоолуурын заалт	Стандарт хэмжил зүйн газраас усны тоолуурын баталгаажуулсан гэрчилгээ, лацаар битүүмжилсэн тоолуурын заалтыг улиралт тутам авах	Тоолуур байгуулсан худаг бүрт	ҮАЗ	-	Улирал бүр	“Усны тухай хууль”, “Усан орчны чанарын үзүүлэлт”
11.	Үйлдвэрт ашигласан усыг дахих эргүүлэн ашиглах	Үйлдвэрт ашигладаг усны 80%-ийг эргүүлэн үйлдвэрийн циклд оруулж эргүүлэн ашиглаж, 20%-ийн чийгшилтэй шламыг хаягдлын даланд хаях	Үйлдвэрт ашигладаг ус	-	-	Уурхайн үйл ажиллагааны турш	Цэвэршүүлсэн бохир усыг дахин ашиглах тохиолдолд Ерөнхий шаардлага MNS 6734:2018
Дүн					500.0		

5.4. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Тэн Хун” ХХК-ийн үйл ажиллагааны улмаас амьтны аймаг үзүүлж болзошгүй дараах нөлөөллийг тодорхойлж, бууруулах арга хэмжээг төлөвлөсөн.

Зураг 22. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах, хууль бус агнуур, шувууд цахилгаанд цохиулах, цахилгааны утас мөргөх гэх мэтээр үхэж, хорогдох эрсдэлтэй	Уурхайн үйл ажиллагааны талбай, дэд бүтцийн шугам дагуух эндсэн амьтны сэг зэмийг зайлуулах, булж устгах	Уурхайн талбай, дэд бүтцийн шугам дагуу	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.	Хур бороо багатай, ган зудтай үед зэрлэг амьтан үхэж хорогдох	Ган зуд болон байгалийн цаг уурын хүнд нөхцөл үүссэн тохиолдолд зэрлэг амьтдыг хамгаалах Биотехникийн арга хэмжээ зохион байгуулах	Төв аймгийн Жаргалант сумын нутагт	-	1 000,0	Цаг үеийн хүнд нөхцөл үүссэн үед	Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Жаргалант сумын байгаль хамгаалагч нарын өгсөн албан зөвлөмжийн дагуу зохион байгуулна.
Дүн					1 000,0		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Тэн Хун” ХХК нь ордын ашиглалтын явцад эвдрэлд орох талбайнуудыг нөхөн сэргээж, аль болох байгалийн унаган төрхөд нь ойртуулах засах зорилт тавьж ажиллана. Байгаль орчныг хамгаалах, байгаль орчны хяналт, шинжилгээний ажлын менежментийн хөтөлбөрийг боловсруулан ажиллах ба байгаль орчин, нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөлтөд Монгол улсад хүчин төгөлдөр холбогдох хууль тогтоомж, стандартуудыг мөрдлөг болгон ажиллана.

Эдгээр үйл ажиллагаа нь “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага (MNS 5917:2008)” стандартад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэх ба нөхөн сэргээлтэнд шаардагдах зардлыг Байгаль орчин, Аялал жуучлалын яамны сайд, Эрдэс баялаг, Эрчим хүчний яамны сайдын хамтарсан 2010 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тооцно. Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Тэн Хун” ХХК-иас төсөл хэрэгжих талбайд хавар болон намрын улиралд бүх нийтийн мод тарих өдөрлөг зохион байгуулна.

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Биологийн нөхөн сэргээлт	Нарсны 2-3 настай суулгацыг тарих	10 000	3,000	30 000,0	Жилийн турш	MNS 5918:2008
2.	Техникийн нөхөн сэргээлт	Гадаад овоолго шимт хөрсний овоолго хэлбэржүүлэх, засаж янзлах	Тодорхойгүй	-	ҮАЗ	Жилийн турш	MNS 5916:2008

3.	Арчилгаа, тордолгоо	Биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийсэн газар	-	ҮАЗ	-	Уурхайн үйл ажиллаганы турш	Нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлт хийх дотоод журам
Дүн				30 000,0			

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн талбайд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.

Зураг 23. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Түүх, соёлын дурсгалт өвийг хамгаалах	Түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөхгүй байх талаа ажилчдад сургалт, зааварчилгаа өгөх	Уурхайн ажилчид	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Соёлын өвийг хамгаалах тухай
2.	Шинэ олдвор шинээр илрэх үед хамгаалах	Төслийн үйл ажиллагааны явцад хийгдэх ухалт малталт, газар шорооны ажлын үед археологи, палеонтологийн олдвор шинээр илрэх тохиолдолд зохих арга хэмжээг авч ажиллах	Төслийн нийт талбайд	ҮАЗ	-	Шинээр олдвор илрэх үед	Соёлын өвийг хамгаалах тухай
Дүн				--*--			

9. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох нөлөөллийг шатлалттайгаар багасгах зарчмыг баримтлана. Энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа нэн түрүүнд тэрхүү нөлөөллөөс зайлсхий, бууруулах, нөхөн сэргээх арга замаар хийгдэнэ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11-д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг.

Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Зураг 24. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	Жаргалант сумын засмал зам дагасан ногоон байгууламжийн төслийн ажилд хөрөнгө оруулалт хийх	Дүйцүүлэн хамгаалахаар сонгосон талбайд	ҮАЗ	-	2024 онд	
		Мониторингийн хяналтын цэгийг тогтоож тогтмол хяналт тавих	Уурхайн мониторингийн цэгүүд	ҮАЗ	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
		Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдах “Тэр бум” модны хүрээнд	5 000 ш	5000	25 000,0	Төслийн бүх үе шатанд	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөр, Орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагуудтай хамтран уг ажлыг зохион байгуулах
		Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр ажилчдад сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	500,0	500,0	Төслийн бүх үе шатанд	
Дүн					25 500,0		

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийг хүрээнд “Тэн Хун” ХХК нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11-д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ” гэж тодорхойлсон.

Мөн хуулийн 8.4.6-д “Газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд хаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ” хэрэгжүүлэх, 9.6-д “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна” гэж тус тус заасныг үндэслэн манай компани Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдах “Тэрбум үндэсний хөдөлгөөн”-ны хүрээнд БОАЖЯ, Төв аймгийн БОАЖГ-тай хамтран ажиллах, аймгийн урт хугацааны төлөвлөгөөтэй уялдуулан ажиллахаар төлөвлөж байна.

10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нарантолгойн уурхайн одоогийн батлагдсан хүчин чадал, үйл ажиллагаа болон түүнд шаардагдах химийн бодисын байгаль орчинд нөлөөлөх байдал, эрсдэлийг тодорхойлохоор дараах эрсдэлийн үнэлгээнүүдийг хийлгэж мөрдлөг болгон ажиллаж байна.

Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Химийн бодисын ашиглалтын эрсдэл	Технологийн шат дамжлага бүрт хэрэглэгдэж буй аюулгүй ажиллагааны зааварчилгааг Байгаль орчин эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчаар хянуулах	Нарантолгойн уурхайн талбайд химийн бодис ашиглаж байгаа бүх хэсгүүдэд	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 2 дугаар бүлэг
2.	Химийн бодис, бүтээгдэхүүний хадгалалтын эрсдэл	Идэмхий бодис хадгалдаг зэвэрч, цоорох эрсдэлтэй төмөр хийцтэй чингэлэгийн дээврийг байнга хяналт тавьж шалгах	Химийн бодисын агуулах	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 2 дугаар бүлэг
		Химийн бодисын ил задгай агуулахыг байгалийн цаг агаарын хүчин		500.0	500.0	2025	Химийн хорт болон аюултай бодисын

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		зүйлийн нөлөөгөөр гэмтэж, чанараа алдахаас сэргийлж дээвэр бүхий саравчтай болгох					тухай хууль 2 дугаар бүлэг
		Адсорбцийн колонны битүүмжлэлийг засах, алдагдлыг зогсоох, идэвхжүүлсэн нүүрсний өгөлтийг тохиромжтой хэмжээнд байлгах		2 000.0	2 000.0	2025	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 2 дугаар бүлэг
3.		Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр агуулах тус бүрийг хангах		3 000.0	3 000.0	Осол гарсан үед	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 2 дугаар бүлэг
№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
4.		Химийн бодис, бүтээгдэхүүний сав баглаа боодлыг агуулах, контейнерт хадгалахдаа эмх цэгцтэй, овор хэмжээг нь багасгаж хадгалах дээр анхаарах		-	-	Жилийн турш	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 2 дугаар бүлэг
5.		Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаарх дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах		-	-	Жил бүр	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 3 дугаар бүлэг
6.	Гал түймэр гарах эрсдэл	Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	Дадлага сургуулилтыг зохион байгуулах	1 000,0	1 000,0	Жилд 1 удаа	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 3 дугаар бүлэг
7.		Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах		2 000,0	2 000,0	Жил бүр	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

							найруулга/ 3 дугаар бүлэг
8.		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх	2 000,0	2 000,0	Жил бүр	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 3 дугаар бүлэг
9.		Шатахууны болон тэсрэх бодисын агуулахын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, тодорхой ажилтанд хариуцуулах		-	-	2025	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 3 дугаар бүлэг
10.	Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах		-	-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө	
№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
11.		Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах		Гэрээний үнийн дүнгээр	-	Жилд 1 удаа	Аюулгүй ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй эрүүл ахуйн тухай хууль
12.		Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохилдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг, ажлын байрт байрлуулах		600,0	600,0	Жил бүрийн 1-р улиралд байрлуулан сар бүр шалгах	Аюулгүй ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй эрүүл ахуйн тухай хууль

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

13.		Уусмал дамжуулах хоолойн механик баг бөхөд агаарын температураас учраас болон нөлөөллийг багасгахын тулд өвлийн улирлын ид хүйтэн буюу 12, 1 сарын үеийн хүйтэн өдрүүдэд уусмал дамжуулах хоолойд тавих хяналтыг нэмэгдүүлэх		Үйл ажиллагааны зардалд тусгасан ХАБЭА	-	Жилд 1 удаа	Аюулгүй ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй эрүүл ахуйн тухай хууль
14.		Үйлдвэр, аваарын усан сангийн үер уснаас хамгаалах далан, суваг, түймрийн зурвасны найдвартай ажиллагаанд хяналт тавих, засвар шинэчлэлийг тогтмол хийж байх		-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
15.		Үйлдвэрийн тоног төхөөрөмж, шугам хоолойн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж байх		-	-		
16.	Аюул осол гарсан тохиолдол	Химийн бодис асгарч хөрсөнд алдагдах тохиолдолд холбогдох арга хэмжээг авах	Ослын цар хүрээнээс хамаарч хөрөнгийг бүрдүүлнэ.	-	-	Болзошгүй осол, аюул эрсдэлийн үнэлгээний зөвлөмжид тусгав.	
№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
17.	Аюул осол гарсан тохиолдолд	Химийн бодис асгарч усанд алдагдах тохиолдолд холбогдох арга хэмжээг авах		Ослын цар хүрээнээс хамаарч хөрөнгийг бүрдүүлнэ.		Болзошгүй осол, аюул эрсдэлийн үнэлгээний зөвлөмжид тусгав.	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
18.		Химийн бодис асгарч агаарт их хэмжээгээр уурших тохиолдолд холбогдох арга хэмжээг авах					Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
19.		Химийн бодис асгарч хүн, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх тохиолдолд холбогдох арга хэмжээг авах					Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

20.	Орон нутагт аюул осол тохиолдолд анхаарал бэлтгэлтэй байх, зөвлөмжийг ашиглах				Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
Дүн				11 100,0	

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын тухайн хуулийн 10.2-т заасны дагуу хэд хэдэн үүргүүдийг бүрэн хүлээж 2025 онд төлөвлөхөөр ажиллана. “Тэн Хун” ХХК нь өнгөрсөн 2024 онд Төв аймгийн Жаргалант сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2022 оны 10-р сарын 14-ний өдрийн 02 тоот тогтоолыг үндэслэн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчтай хаягдлын төлбөр хураамж төлөх талаар харилцан тохиролцож гэрээ байгуулсан. 2025 онд хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор аж ахуй нэгж нь үйл ажиллагаагаа эрхлэхдээ дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 10. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн болон үйлдвэрийн	Энгийн хог, хаягдлыг тээвэрлэх, орон нутагтай хамтарсан гэрээг жил тутам сунгалт хийх	Төв аймгийн Жаргалант сумын ЗДТГ	200,0	2 400,0	Жил бүр	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.3 болон 10.2.7-т заасны дагуу
2.	Энгийн хог хаягдал	Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх	Үйл ажиллагаа явуулж буй байршилд	ҮАЗ	-	Жил бүр	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1 болон энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу
3.	Шаардлага хангасан хогын савыг байршуулах	Хог хаягдлыг ангилан ялгах, галд тэсвэртэй материалаар салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлэх хогын савуудыг байршуулах	Уурхайн гол гол хэсэгт	ҮАЗ	-	Жил бүр	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.2 болон энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу
4.	Нийтийг хамарсан их	Нийтийг хамарсан цэвэрлэгээ, сум орон нутаг болон ТББ, иргэдээс зохион байгуулсан үйл ажиллагаанд	Бүх ажилчин албан хаагчид	ҮАЗ	-	Жил бүр	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.6-т заасны дагуу

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	цэвэрлэгээ зохион байгуулах	байгууллагын зүгээс хамтран оролцох, зохион байгуулах					
5.	Хог хаягдлын талаар сургалт зохион байгуулах	Хагас жил тутамд байгууллагын нийт ажилчин, албан хаагчдад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг бий болгож хэвшүүлэх	Уурхайн бүх ажилтнуудад	ҮАЗ	-	Хагас жил тутамд	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.16-т заасны дагуу
№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
6.	Ахуйн болон үйлдвэрийн	Дахин ашиглах боломжгүй хог хаягдлыг булшлах	Уурхайн хэмжээнд	ҮАЗ	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын тухай хууль
7.	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх ажиллагааг журамлаж, бусад төрлийн хог хаягдалтай холихгүй тусад нь тээвэрлэж тусгай зориулалтын газар хадгалах, устгах. Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх	Хог гаргаж байгаа харьяа нэгжүүд	10 000,0	10 000,0	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.5-т заасны дагуу
8.	Ахуйн болон үйлдвэрийн	Хог хаягдал үүсгэгч болон эрх бүхий иргэн ААН, байгууллага нь батлагдсан маягтын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүрт нь хөтөлж, энэ журмаар тогтоосон хугацаанд тайлангаа сум, дүүргийн Засаг дарга эсхүл түүний томилсон этгээдэд хүргүүлэх	Хариуцсан ажилтан	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын тухай хууль
9.	Ахуйн болон үйлдвэрийн	Хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах үндэсний компаниудтай хамтран ажиллах	Уурхайн хэмжээнд	ҮАЗ	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын тухай хууль
10.	Нүхэн жорлон ариун цэврийн хангаж халдварт	Уурхайн ажилчдын амьдрах аюулгүй орчин бүрдүүлэх, байгаль орчныг	Уурхайн нүхэн жорлонгийн хэсэгт	ҮАЗ	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн

өвчнөөс урьдчилан сэргийлэх	бохирдлоос хамгаалах, халдварт өвчин үүсэхээс урьдчилан сэргийлэх					шаардлага MNS 5924:2015 стандартын дагуу
Дүн			12 400,0			

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч “Тэн Хун” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг жил бүр 11-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах

№	БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1.	Сум, багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон хяналт шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11- сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах, хамтран ажиллах	Сумын ИТХ-ын танхим
2.	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тухайн жилийн БОМТ, тайлан	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12- сар	-	-

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөлтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчны асуудал нь зөвхөн байгаль орчны ажилтан, мэргэжилтэнүүд анхаарал хандуулах биш захирлаас эхлээд тогооч, цэвэрлэгч, жолооч гээд уурхайн бүхий л ажилтануудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалт төлөвлөгөө

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1.	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Тусгай зөвшөөрөлтэй талбай	Гэрээний үнийн дүнгээр	Өмнө хийлгэснээс 5 жилийн дараа	Газрын тухай хуулийн 58.5
№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
2.	Байгаль орчныг хамгаалах тухайн хуулийн 10 дугаар зүйлийн 10 болон БО-ны ерөнхий үнэлгээний шаардалагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх	2 жил тутамд	Гэрээний үнийн дүнгээр	2 жил тутамд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
3.	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Тохиролцох	Төслийн хугацаанд	Нийгмийн хариуцлагын гэрээ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
4.	Уурхайн гадаад тээврийн замыг засч сайжруулах тээврийн компанитай хамтран ажиллах	Уурхайн гадаад тээврийн зам	Уурхайн зардлаас	2021-2025	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Дүн			-		

14. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас орчны агаар, ус, хөрсөнд үзүүлэх нөлөөллийг илрүүлэх, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан арга хэмжээний дүнг хянаж шалгах, цаашдын үйл ажиллагааг тодотгох зорилгоор хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Орчин хяналт шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжих газрын агаарын чанар, усны чанар, хөрсөн бүрхэвч, дуу чимээний нөлөөлөл зэрэг хяналт шинжилгээний үзүүлэлт, хэмжилт хийх, дээж авах байршил, хугацаа, давтамж, холбогдох стандарт болон

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

эдгээр ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зардлын төсвийг тооцоолов. ОХШХ-ыг байгаль орчны мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлж, хяналт тавьж, тухайн бүрд нь тайлагнан ажиллана.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Тэн Хун” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагатай гэрээтэй оролцуулна.

14.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ

Агаарын чанарт үзүүлэх нөлөө, цаашлаад агаарын чанарын холбогдох стандарт шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянахын тулд Нарантолгойн уурхайд хэмжилтийн багажаар хэмжилтийн багажаар хэмжилт хийх, мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх зэрэг доор дурдсан хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 13. Агаарын чанарын хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал, жилд (мян.төг)	Нийт зардал 1 жил мян.төг	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1.	Агаарын тоосны шинжилгээг хийлгэх /Нийт PM10, PM2.5/	Уурхайн үйл ажиллагаанаас агаарт тоосжилт үүсэх, тархах	Үйлдвэрийн районд	Жилд 2 удаа	100,0	400,0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS 4990:2000 Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
2.	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Уурхайн үйл ажиллагаанаас агаар бохирдуулагчийн хэмжээг тогтоох	Үйлдвэрийн районд	Дулааны улиралд 2 удаа	300,0	600,0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.	Дуу шуугиан, чичиргээ	Өрөмдлөг, тэсэлгээ, машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх	Үйлдвэрийн районд, далд уурхай	Улиралд 1 удаа	500,0	500,0	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага, Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолын хавсралт “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” MNS 4585:2016 Гадаад орчны дуу чимээний хүлцэх хэмжээ MNS 4995:2015 Ажлын орчинд дуу чимээний давтамж болон хэлбэлзэл
						1 500,0	

14.2. Хөрсний хяналт шинжилгээ

Хөрсний дээж авах цэгүүдийг сонгохдоо бохирдолтой байж болзошгүй хэсгээс сонгож түүвэрлэх аргыг ашиглан, Байгаль хамгаалах. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1991 стандартад заагдсан арга, аргачлалыг мөрдөж ажиллана. Хөрсний бохирдлын гол үзүүлэлт болох хүнд металлууд нь задарч алга болдоггүй хөрсөнд удаан хугацаагаар хуримтлагдаж ус болон ургамлаар дамжин хүн, мал, амьтны бие организмыг молекулын ба гений түвшинд хордуулдаг. Хөрсөн дэх хүнд металлын агууламжийг “Хөрсийн чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019 стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үнэлнэ.

Уурхайн үйл ажиллагааны үр дүнд хөрсний хими, физикийн шинж чанар, хүнд металлын агууламжид гарч болох өөрчлөлт, мөн түүнчлэн хөрсний чанар нь холбогдох стандартын шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянах зорилгоор хяналт шинжилгээтэй холбоотой доорх ажлыг 2025 онд хийхээр төлөвлөж байна.

Хүснэгт 14. Хөрсний хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал, жилд (мян.төг)	Нийт зардал 1 жил мян.төг	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
---	-----------------------------------	---	-------------------------------	--------------------	-----------------------------------	---------------------------	---

“ТЭН ХУН” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

